



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
МОНГОЛ УЛСЫН
ДАЛАЙН ЗАХИРГАА

Лagшан төв, Ерөнхий сайд Амарын гудамж,
8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976-51) 26 14 89, 26 14 90, Факс: (976-11) 31 06 42
Цахим шуудан: info@monmarad.gov.mn
Цахим хуудас: www.monmarad.gov.mn

2024.12.23 № 01/553
танай _____-ны № _____-т

ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Далайн захиргаанаас Монголд
зочлох жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг
жилийн эцсийн байдлаар хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 7... хуудастай

ЗАХИРГАА, УДИРДАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА . Т.МӨНХБАЯР



00000522

**“МОНГОЛД ЗОЧЛОХ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД 2024 ОНД ДАЛАЙН ЗАХИРГААНААС
ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

/Жилийн эцсийн байдлаар/

2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

№	Зохион байгуулах арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хариуцах алба	Биелэлт
1	Орон нутгийн зорчигч тээврийн том оврын тээврийн хэрэгслийн дэлгэцээр гаргахаар “Хийлдэг завь тоглоом биш”, “Аврах хантаазаа өмс” аяны видео шторк, танилцуулгыг бэлтгэх, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах	IV-VIII сар	ЗУХ УЗТБХХ	<p>“Монголд зочлох жил”-ийн лого, брендингтэй уялдуулан дараах ажил, арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Усан замын тээврийн хэрэгслээр үйлчлүүлэгч нарт зориулсан аюулгүй ажиллагааны самбарыг захиалгаар хийлгэж, Хөвсгөл, Өгий нууруудын эрэг дагуу усан замын зогсоол, отоглох цэг зэрэг газруудад нэмж байрлуулсан. -Аврах хантааз бүхий стикер /наалт/-ийг шинэчлэн хэвлүүлж, техникийн хяналтын үзлэгт тэнцсэн усан замын тээврийн хэрэгслүүдэд олгоод байна. -Салбарын онцлогийг харуулж, үйл ажиллагааны чиглэлийг илэрхийлсэн танилцуулга, брошур, стикер, анонс, тараах материалуудыг шинэчлэн хэвлүүлж аж ахуйн нэгж, иргэдэд түгээж сурталчлан мэдээлэл өгч ажилласан. -Усан замын тээврийн аюулгүй ажиллагааг сайжруулах, олон нийтэд сэрэмжлүүлэг өгөх ажлын

				хүрээнд “Хийлдэг завь тоглоом биш”, “Аврах хантаазаа өмс” уриатай богино хэмжээний видео шторкийг англи хадмал орчуулгатай, дохионы хэлмэрчтэй байдлаар хийж, салбарын иргэдэд үйлчилгээ үзүүлдэг төвүүдийн болон хот хоорондын зорчигч тээврийн автобусны дэлгэцүүдээр гаргахын сацуу цахим сүлжээнд байршуулсан.
2	Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан усан замын тээврийн хэрэгслүүдийг ялган таниулах зорилготой тусгай наалтыг “Монголд зочлох жил”-ийн брендингтэй нийцүүлэн шинээр боловсруулж, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	VI-VIII сар	ЗУХ УЗТБХХ	Техникийн хяналтын үзлэгт хамрагдаж, тэнцсэн усан замын тээврийн хэрэгслүүдэд “Монголд зочлох жил”-ийн брендингтэй нийцүүлсэн стикер хэвлүүлж, байршуулан сурталчилан ажилласан. 2024 оны байдлаар 124 усан замын тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт тэнцсэн байна.
Арга хэмжээ 2.2. Харьяа байгууллага, төрийн өмчит компаниуд “Монголд зочлох жил”-ийн (2023-2025) хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүрээр гарган баталж, хэрэгжилтийг хангах				
3	“Монголд зочлох жил”-ийн (2023-2025) хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүрээр гарган баталж, хэрэгжилтийг хангах	VI-XII сар	ЗУХ УЗТБХХ	Далайн захиргааны даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар “Монголд зочлох жил”-ийн хүрээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
Арга хэмжээ 2.2. Харьяа байгууллагууд “Монголд зочлох жил”-тэй холбоотой медиа контент, сурталчилгааны бүх төрлийн материал бэлтгэж, нэгдсэн мэдээлэл, удирдлагаар хангах				
4	“Монголд зочлох жил”-тэй холбогдуулан салбарын онцлогийг харуулсан танилцуулга, брошур, стикер, видео танилцуулга хийж, байршуулах	IV-VI сар	ЗУХ УЗТБХХ	Голл, мөрөн, нуур бүхий аймгуудын нэвтрэх пост, эрэг дагуу зогсоол, отогох цэгүүдэд усан замын тээврийн аюулгүй ажиллагааг

				сайжруулах, олон нийтэд сэрэмжлүүлэг өгөх ажлын хүрээнд “Хийлдэг завь тоглоом биш”, “Аврах хантаазаа өмс” уриатай богино хэмжээний видео шторкийг англи хадмал орчуулгатай, дохионы хэлмэрчтэй байдлаар хийж, салбарын иргэдэд үйлчилгээ үзүүлдэг төвүүдийн болон хот хоорондын зорчигч тээврийн автобусны дэлгэцүүдээр гаргахын сацуу цахим сүлжээнд байршуулсан.
<p>Арга хэмжээ 2.2. Зам, тээврийн салбарт аялал, жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, бүх төрлийн тээврийн зорчигч тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах</p> <p>Арга хэмжээ 2.13. Зам, тээврийн салбарт олон улс, орон нутгийн аяллын тоо, чиглэл нэмэгдүүлэх, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, хүртээмжтэй болгох, аяллын тийзийн үнэ бууруулах чиглэлд цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх</p>				
5	Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах зорилгоор усан замын тээврийн салбарт хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	VI-XII сар	УЗТБХХ	Төлөвлөгөөний дагуу 2024 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, Ховд аймгийн Буянт гол, Архангай аймгийн Өгий нуур болон Хөвсгөл нуурын эрэгт усан замын хөвдөг зогсоолуудыг тус тус суурилуулсан. Мөн Хөвсгөл нуурын усан замын зосгоол, Сом хад, Жанхайн эрэгт зөөврийн хяналтын камер бүхий усан замын чиглүүлэгч төхөөрөмжийг суурилуулсан.
6	Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч ААН, иргэдтэй хамтран Хөвсгөл нууранд Хатгал-Ханх чиглэлд усан замын зорчигч тээврийн үйлчилгээг эхлүүлэх боломжийг судлах, туршилтын тээвэр явуулах	VI-IX сар	УЗТБХХ	Хөвсгөл нуурын онцлогоос хамаарч иргэдийн аюулгүй байдлыг харгалзан үзэж, салхи, давлагаанд тэсвэртэй, хүчин чадал сайтай, олон хүний суудалтай дунд оврын зорчигч тээврийн зориулалттай усан онгоцыг Хатгал-Ханх чиглэлд

			<p>усан замын зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглах үүднээс Хөвсгөл нуурт усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч "Грейт Си Тур" ХХК-ийн 60 хүний суудалтай, дунд оврын зорчигч тээврийн зориулалттай усан онгоцыг явуулах нь тохиромжтой гэж үзэн тус компанийн удирдлага болон холбогдох албан хаагчидтай уулзаж, туршилтын тээврийг эхлүүлэх талаар харилцан тохиролцсон. Гэвч туршилтын тээвэрт ашиглах усан замын тээврийн хэрэгслийн 2 хөдөлгүүрийн нэг нь доголдож, ОХУ-аас засварын мэргэжлийн баг урьсан байсан нь тодорхой шалтгаанаар хойшилсон байна. Иймд туршилтын тээвэр хийх ажил 2025 он хүртэл хойшлоод байна. "Грейт си тур" ХХК-иас Далайн захиргаанд 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр тайлбар хүргүүлсэн. 2025 онд туршилтын тээврийг эхлүүлэхээр төлөвлөж байна.</p>
<p>Арга хэмжээ 2.6. Харьяа байгууллагууд, төрийн өмчийн компаниуд гадаад, дотоодын жуулчдад үзүүлдэг үйлчилгээг бүрэн цахимжуулж, хүнд сурталгүй, түргэн шуурхай үзүүлэх.</p> <p>Арга хэмжээ 2.7. "Монголд зочлох жил"-ийн хүрээнд нисэх онгоцны буудал, төмөр замын буудал, автобуудал, зам дагуух үйлчилгээний цогцолбор болон замын хажуугийн түр зогсоол, жуулчдад үйлчилгээ үзүүлэх төв, тээврийн үйлчилгээний газруудыг хаяг, өнгө, үзэмжийг сайжруулах, үйлчилгээний газрын хаяг, танилцуулгыг монгол, англи болон шаардлагатай тохиолдолд бусад гадаад хэл дээр байршуулах.</p> <p>Арга хэмжээ 2.8. Зорчигч тээврийн үйлчилгээний албан хаагчдын дүрэмт хувцсыг шинэчлэх, сайжруулах, байгууллагын цахим хуудсыг англи болон бусад хэлээр хөтлөх, жуулчдад чиглэсэн мэдээ, мэдээллийг тогтмол оруулж байх</p>			

Арга хэмжээ 4. Нийт усан замын тээврийн хэрэгслийг үзлэг оношлогоонд оруулах, тээврийн аюулгүй байдлыг хангах, автозамын бэлэн байдлыг шалгаж, холбогдох тайланг улирал тутам танилцуулах				
7	Байгууллагын цахим хуудсыг англи болон бусад хэлээр хөтлөх, жуулчдад чиглэсэн мэдээ, мэдээллийг тогтмол нийтлэх	VI-XII cap	ЗУХ	Байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд шинэ, шинэлэг мэдээ мэдээллийг англи, монгол хэлээр тогтмол байршуулж байна.
8	Усан замын тээврийн хэрэгслийн жолооч нарыг тусгай хувцсаар жигдрүүлэх, зорчигч тээврийн бүх төрлийн тээврийн хэрэгслийн дотор, гадна өнгө үзэмж, улсын дугаар болон үйлчилгээний зориулалтын тоног төхөөрөмж, хэрэгслүүд нь стандартын шаардлага хангасан байх, техникийн бүрэн бүтэн байдалд үзлэг, оношилгоо хийж, аюулгүй ажиллагааг хангуулах	VI-IX cap	УЗТБХХ	Усан замын тээврийн хэрэгслээр зорчигчдод үзүүлэх үйлчилгээг сайжруулах, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол танилцуулж, дагаж мөрдөх, тээврийн хэрэгслийн дотор, гадна өнгө үзэмжид анхаарах, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж хөвөлтөд гарах ажлуудыг зохион байгуулсан. Батлагдсан хуваарийн дагуу усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн улсын хэмжээнд зохион байгуулж ажилласан.
Арга хэмжээ 2.16. Байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйлчилгээг өргөжүүлэх, салбарын хэмжээнд хог хаягдал, агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлд төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, олон улсын байгууллага, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах санал санаачилга гарган ажиллах				
9	Байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйлчилгээг өргөжүүлэх, салбарын хэмжээнд хог хаягдал, агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлд төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, олон улсын байгууллага, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах санал санаачилга гарган ажиллах	VI-XII cap	ЗУХ УЗТБХХ	Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах зорилгоор эрэг орчмын хог хаягдлыг түүж цэвэрлэх, зайлуулах ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд 6 дахь жилдээ зохион байгууллаа. Хүзүүвчийн шилд байрлалтай “Леона ресорт” жуулчны баазаас “Нефть бааз”-ын хашаа, Усан замын зогсоол хүртэл нуурын эрэг орчмын хог хаягдлыг түүж, цэвэрлэх ажлыг зохион байгуулсан. Энэхүү ажлын

				<p>үр дүнд нийт 27 шуудай хог хаягдлыг түүж, эргээс зайлуулсан бөгөөд түүсэн хогийг 3 хэсэгт ангилан ачиж, Хатгал тосгоны хогийн цэгт тээвэрлэн хүргэж, хүлээлгэн өгөв.</p>
10	<p>Хөвсгөл, Тэрхийн цагаан, Өгий, Хяргас, Буйр зэрэг томоохон нуурын усан замын зогсоол, усан замын тээврийн хэрэгслүүдэд тогтоосон хугацаанд техникийн үзлэг хийж, бэлэн байдлыг хангуулах, завьчдын мэргэжлийн үнэмлэхийг шалгах ажлыг зохион байгуулах</p>	VI-IX сар	УЗТБХХ	<p>Усан замын тээврийн техникийн хяналтын үзлэгийг батлагдсан удирдамж, хуваарийн дагуу удирдамж, хуваарийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Архангай аймгийн Өгий нуур, Тэрхийн цагаан нуур, Баян-Өлгий аймгийн Толбо нуур, Увс аймгийн Хяргас нуур, Ховд аймгийн Хар ус, Далай нуур, Дорнод аймгийн Буйр нуур, Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ мөрөн, Булган аймгийн Эг, Үүрийн бэлчир, Хөвсгөл аймгийн Тэнгис-Шишгэдийн бэлчирт тус тус зохион байгуулсан. улсын хэмжээнд зохион байгуулж ажилласан.</p> <p>Мөн “Усан замчны толь бичиг” НҮТББ сургалтын төвийн мэргэжлийн сургалтаар усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн сургалтад хамрагдсан иргэдээс мэдлэг, ур чадварыг үнэлэх, баталгаажуулах ажлыг дээрх институтийн гэрчилгээжүүлэлт хариуцсан арга зүйчийн хамт Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2024 оны 08 дугаар сарын 14-15 өдрүүдэд, Архангай аймгийн Өгийнуур суманд 2024 оны 07</p>

				дугаар сарын 01-02 ны өдрүүдэд, Булган аймгийн Хантай багт 2024 оны 08 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд тус тус зохион байгуулж, 21 хүнд усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн үнэмлэх олгосон.
--	--	--	--	---

---oOo---